



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/190

Хэрлэн сум

Хэвлэмэл материал хийлгэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулсан “Хөдөөгийн сэргэлт” чуулганы үеэр Улаанбаатар хотоос шилжин ирэх иргэдэд мэдээ мэдээлэл хүргэх, нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор хэвлэмэл материал хийлгэхэд 1,100,000 (нэг сая нэг зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 28 -ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	"Хөдөөгийн сэргэлт" сэтгүүл	4 нүүр	250,000	1,000,000
2.	Стэнд	2 ш	50,000	100,000
3.	Нийт			1,100,000